











**СЭДЭВ:** МНБ-ийн эрхийг шинээр авсан гишүүдэд мэдээлэл хүргэх болон гишүүний эрх үүргийн тухай

**ЧАТЫН УДИРДАГЧ:** Салбар хариуцсан менежерн менежер Т.Намхай

**ХЭЗЭЭ:** 2016/03/25

**ЦАГ:** 14:00

**ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА:** 1 цаг

 <b>ММНБИ</b>	 <b>Зочин420</b>	 <b>Зочин740</b>
 <b>Салбар хариуцсан менежер</b>	 <b>Зочин141</b>	 <b>Зочин774</b>
	 <b>Зочин653</b>	 <b>Зочин991</b>
	 <b>Зочин289</b>	 <b>Зочин221</b>
		<b>Нийт: 8 зочин</b>

14:02:46 <**Салбар хариуцсан менежер**> Сайн байцгаана уу? Та бүхний амар амгаланг эрье.

14:03:12 \* **Зочин991** ийг Миний талбар урилаа

14:03:18 <**Салбар хариуцсан менежер**> Юуны өмнө та бүхэндээ Монгол улсын Мэргэшсэн нягтлан бодогчийн болзлыг ханган эрх авсанд баяр хүргэе.

14:03:48 <**Салбар хариуцсан менежер**> Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх авсан хувь хүн нь тангараг өргөснөөр ММНБИ-ийн мэргэшсэн нягтлан бодогч гишүүн болдог.

14:04:17 <**Салбар хариуцсан менежер**> Гишүүн болсноор МНБ-ын эрхийг эдэлж, үүргийг биелүүлэх тухай ММНБИ-ийн дүрмийн 5 дугаар зүйлд заасан байгаа

14:06:48 <**Салбар хариуцсан менежер**> Зочин221-т гишүүний татвараа харьяалагдаж буй салбартаа төлнө

14:06:55 <**ММНБИ**> **Сайн байцгаана уу? Өнөөдрийн чат МНБ-ийн эрхийг шинээр авсан гишүүдэд мэдээлэл хүргэх болон гишүүний эрх үүргийн тухай сэдвээр 1 цагийн туршид явагдана**

14:08:32 <**Салбар хариуцсан менежер**> Гишүүн болсноор МНБ-ын эрхийг эдэлж, үүргийг биелүүлэх тухай ММНБИ-ийн дүрмийн 5 дугаар зүйлд заасан байгаа

14:08:49 <**Зочин991**> Sain bna uu? Bid nar surgalt ene terdee hezee hamragdah ve?

14:14:03 <**Зочин141**> Гишүүний татвар нь хэд байдаг, үүнийг төлснөөр бид ямар ямар үйлчилгээг үнэ төлбөргүй авах вэ? Мөн МНБ-ийн гэрчилгээ авахад төлсөн 120,000 төг жилийн татвар нь мөн юмуу. Биш бол юуны төлбөр юм

14:15:14 <**Салбар хариуцсан менежер**> Зочин991, хэрэв та 2015 онд МНБ-ын эрх авсан бол 2017 онд 5 жилийн эрхээ авах сургалтад хамрагдана

14:17:00 <**Салбар хариуцсан менежер**> Зочин991, үүнээс өмнө орон нутгийн салбарууд болон ММНБИ-н УБ салбар, ММБИ нь ТБС-ыг хуваарь гарган зохион байгуулдаг

14:17:56 <**Салбар хариуцсан менежер**> Зочин141, ММНБИ-ийн дүрмийн 6 дугаар зүйлд заасан байгаа

14:18:31 <**Салбар хариуцсан менежер**> 6.1. Институтийн гишүүн нь татвар төлнө. 6.2. Гишүүний татварын хэмжээг Институтийн Удирдах зөвлөл тогтооно. 6.3. Гишүүнд татварын хөнгөлөлт үзүүлж болно.

14:21:11 <**Салбар хариуцсан менежер**> Зочин141, Гишүүний жилийн татвар 120,0 мян/төг жилийн

14:23:01 <**Салбар хариуцсан менежер**> Зочин141, МНБ-ын эрхийг анх авахад төлсөн 120,0 төг бол МНБ-ын гэрчилгээ, тэмдэгтийн хураамж Сангийн яамд төлдөг байгаа

14:23:01 <**Салбар хариуцсан менежер**> Зочин141, МНБ-ын эрхийг анх авахад төлсөн 120,0 төг бол МНБ-ын гэрчилгээ, тэмдэгтийн хураамж Сангийн яамд төлдөг байгаа

14:26:31 <**Салбар хариуцсан менежер**> Зочин141, Гишүүний татвар төлснөөр та МНБ сонин сэтгүүлийг эрхийн бичгээр үнэ төлбөргүй унших, зарим нэг сургалт семинарт хөнгөлөлттэй үйлчлүүлэх зэрэг олон төрлийн зүйлс байдаг

14:27:42 <**Зочин141**> 2015 оны 12 сард МНБ болсон хүн хуучин хуулиараа 7 жилийн дараа хугацаагүй эрхтэй МНБ болох уу? 4 жил болгож өөрчлөх талаар ямар нэгэн журам гарах уу

14:31:27 <Салбар хариуцсан менежер> Зочин141, та 2 жилийн дараа буюу 2017 онд эрх сунгуулах сургалтад хамрагдана. тэгээд 4 жилийн дараа буюу 2019 онд хугацаагүй эрхээ авах шинэ журмын төсөлд оруулж байгаа

14:32:14 <Зочин141> За баярлалаа

14:32:58 <Зочин141> Өөр хэлж анхааруулах зүйл байна уу?

14:34:37 <Салбар хариуцсан менежер> Гишүүн та харьяалагдаж буй салбарын дарга, менежерүүдтэйгээ холбогдож мэдээлэлүүдийг авч байнга холбогдож байх хэрэгтэй. Мөн 70115315 утсаар холбогдоод тодруулах зүйлс байвал асуугаарай

14:36:42 <Салбар хариуцсан менежер> Манай ММНБИ-ийн веб хуудсаар байнга зочилж мэдээлэл авах, мөн энд Шинэ гишүүдэд зориулав буланд мэдвэл зохих бүх дүрэм журмын талаар дэлгэнгүй танилцана уу

14:37:57 <Зочин141> Тэгнээ баярлалаа

14:38:39 <Салбар хариуцсан менежер> МНБ-ын гишүүдийн бүртгэлийн программд орж өөрсдийн анкет мэдээлэл, үүргийн биелэлт татвар төлөлт зэрэг мэдээлэлээ хянах боломжтой байгаа

14:42:43 <Салбар хариуцсан менежер> . Гишүүдийн эрх 5.1.1. Институтийн бодлого, шийдвэр боловсруулах, хэлэлцэж батлахад оролцох, санал, шүүмжлэл гаргах. 5.1.2. Институтийн аль ч байгууллагад сонгох, сонгогдох. 5.1.3. Институтээс мэргэжлийн холбогдолтой мэдээлэл авах, сургалтанд хөнгөлөлттэй үнээр суралцах ба энэ талаар шаардлага тавих. 5.1.4. Үүргээ гүйцэтгэх, эрхээ хамгаалуулах талаар Институтэд хандан санал, хүсэлт, шаардлага тави

14:43:16 <Салбар хариуцсан менежер> Гишүүдийн үүрэг 5.2.1. Институтийн бодлого, дүрэм, шийдвэрийг хэрэгжүүлэхэд санаачлагатай оролцох. 5.2.2. Ёс зүйн дүрмийн шаардлагыг чанд сахиж, үнэнч шударга ажиллаж, мэргэжлийн нэр хүндийг дээдлэх 5.2.3. Институтээс зохион байгуулж байгаа төлөвлөгөө сургалтад хамрагдан, мэдлэг, үр чадвар, дадлага, туршлагаа байнга дээшлүүлэх. 5.2.4. Гишүүний татвараа жил бүр тогтмол төлөх 5.2.5. Гишүүн байгуулл

14:44:13 <Салбар хариуцсан менежер> гишүүн та жил бүрийн 12 сарын 01-ны дотор ёс зүйн тайлангаа ирүүлж байх ёстой

14:44:55 <Салбар хариуцсан менежер> Ёс зүйн тайланг Гишүүдийн бүртгэл программын ёс зүйн тайлан хэсэгт орон илгээхэд болно

14:46:12 <Салбар хариуцсан менежер> МНБ гишүүн нь жилдээ мэргэжлийн тасралтгүй сургалтаар 40 кт цаг хангасан байх ёстой байдаг

14:48:41 <Салбар хариуцсан менежер> Гишүүдийн үүргийн биелэлтийг дүгнэх журмын дагуу дүгнэнэ

14:49:26 <Салбар хариуцсан менежер> Гишүүдийн үүргийг дүгнэх журмын дагуу 2 жилээс дээш хугацаагаар үүргийн биелэлт хангалтгүй байгаа гишүүдийг ёс зүйн хороонд шилжүүлдэг байгаа

14:51:29 <Салбар хариуцсан менежер> Зочин221, гишүүний татвараа харьяалагдаж буй салбарынхаа дансанд хийдэг. хэрэв та УБ хотод амьдагддаг бол ММНБИ-н УБ салбарт харьяалагдана

14:52:11 <Салбар хариуцсан менежер> Зочин221, та 70007858, 70115315 утсаар холбогдоорой баярлалаа

14:56:31 <ММНБИ> Чат дуусахад 2 минут дутуу байна.

14:58:04 <ММНБИ> Гишүүний эрх үүргийн талаар мэдээлэл хүргэсэн Салбар хариуцсан менежер менежер Т.Намхайд баярлалаа.

14:58:41 <Салбар хариуцсан менежер> чатад оролцсон та бүхэнд баярлалаа

14:58:58 <Салбар хариуцсан менежер> Ажлын өндөр амжилт хүсэе